



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/13-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх	Цахим хаяг: <a href="mailto:Enkhtuyach@audit.gov.mn">Enkhtuyach@audit.gov.mn</a> Б.Батмөнх
Сүхбаатар сум 2024 он	Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-2442	Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a> Б.Наранцэцэг Цахим хаяг: <a href="mailto:Narantsetsegba@audit.gov.mn">Narantsetsegba@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15-16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. Аудитын тайлан	18-19
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БММӨУС	Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
МЭН	Мал эмнэлгийн нэгж
МЭУСАХЗ	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХШҮДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар



СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН  
ГАЗРЫН ДАРГА С.АРИУНТӨГС ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № СГА-2024/12-НЭСТЭГЧЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны 13 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд УМЭАЦТЛ-оос 4 төрлийн тандалт шинжилгээний зардалд 19,895.0 мянган төгрөг, МЭЕГ-аас 6 төрлийн өвчний тарилгын үйлчилгээний хөлс 1,038,239.2 мянган төгрөг, аймгийн ОНХС-гаас МЭУСАХЗ-ын 355,683.6 мянган төгрөг тус тус төвлөрүүлснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр баригдаж буй Мал эмнэлгийн газрын лабораторийн барилга ашиглалтад ороогүй байхад түүнд ашиглагдах тоног төхөөрөмж, лабораторийн шинжилгээний эм урвалжийг

018020474

“Медимпекс интернэшнл” компани 2021 онд урьдчилан нийлүүлж, 94,544.6 мянган төгрөгийн урвалжийн хугацаа дуусаж, ашиглалтгүй болсон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 4 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 99.9 хувьтай тайлагнасан боловч албан ёсны үнэлгээ хийгдээгүй байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>207,063,828.84</b>	<b>298,931,979.34</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>120,282,810.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	120,282,810.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>207,063,828.84</b>	<b>178,649,169.34</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>114,987,549.54</b>	<b>116,049,793.54</b>
35130	Эм боох материал	114,987,549.54	116,049,793.54
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>92,076,279.30</b>	<b>62,599,375.80</b>
35410	Бичиг хэргийн материал	353,250.00	1,340,966.00
35420	Аж ахуйн материал	1,120,142.50	197,100.00
35440	Түлш, шатах тослох материал	3,878,820.00	5,964,400.00
35470	Бусад хангамжийн материал	86,724,066.80	55,096,909.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,567,694,086.43</b>	<b>1,391,608,281.20</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,567,694,086.43</b>	<b>1,391,608,281.20</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,433,165,753.17</b>	<b>1,257,535,947.94</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	53,712,918.93	49,263,241.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,140,563.40	-21,218,147.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148,356,300.00	148,356,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-61,585,363.44	-73,803,373.44
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,548,730,409.00	1,575,935,409.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-358,946,357.38	-533,013,362.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,580,548.60	168,242,148.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,542,139.14	-56,226,568.06
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>134,528,333.26</b>	<b>134,072,333.26</b>
39301	Программ хангамж	2,280,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,294,666.74	-1,750,660.74
39303	Бусад биет бус хөрөнгө	133,543,000.00	133,543,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,774,757,915.27</b>	<b>1,690,540,260.54</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>49,785,750.00</b>	<b>120,282,810.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>49,785,750.00</b>	<b>120,282,810.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>49,785,750.00</b>	<b>120,282,810.00</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	59,850,000.00
413209	Эмийн өглөг	0.00	59,850,000.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>49,785,750.00</b>	<b>60,432,810.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	49,785,750.00	60,432,810.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,724,972,165.27</b>	<b>1,570,257,450.54</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,724,972,165.27</b>	<b>1,570,257,450.54</b>
<b>51101</b>	<b>-Төрийн</b>	<b>39,415,000.00</b>	<b>39,415,000.00</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,685,557,165.27</b>	<b>1,530,842,450.54</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,909,092,601.48	1,685,557,165.27
51220	Тайлант үеийн үр дүн	-223,535,436.21	-154,714,714.73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,774,757,915.27</b>	<b>1,690,540,260.54</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,516,111,292.55</b>	<b>4,109,557,707.06</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>786,392,032.65</b>	<b>1,375,026,177.06</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>786,392,032.65</b>	<b>1,375,026,177.06</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>10,833,450.00</b>	<b>27,914,350.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,833,450.00	27,914,350.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	81,463,519.00	47,731,837.41
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	694,095,063.65	1,299,379,989.65
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,729,719,259.90</b>	<b>2,734,531,530.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>925,871,600.00</b>	<b>1,184,410,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	925,871,600.00	1,184,410,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>803,847,659.90</b>	<b>1,550,120,630.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	403,510,499.90	491,986,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	400,337,160.00	1,058,134,220.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,739,646,728.76</b>	<b>4,264,272,421.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,739,646,728.76</b>	<b>4,264,272,421.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,621,872,183.48</b>	<b>4,020,990,532.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>440,157,409.17</b>	<b>731,404,118.18</b>
210101	Үндсэн цалин	343,823,260.29	543,246,594.50
210102	Нэмэгдэл	48,286,809.83	127,644,377.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,715,100.00	22,526,934.14
210104	Урамшуулал	23,332,239.05	37,986,212.05
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,748,214.33</b>	<b>97,922,798.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,400,347.76	65,717,475.62
210202	Тэтгэмжийн даатгал	4,517,687.96	7,392,589.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,018,438.07	10,307,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	801,067.65	1,318,666.73
210205	Эрүүл мэндийн даатгал	8,010,672.89	13,186,666.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,007,897.90</b>	<b>19,123,647.11</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,079,797.90	5,239,667.11
210302	Түлш, халаалт	12,928,100.00	13,883,980.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,833,590.00</b>	<b>34,457,647.50</b>
210401	Бичиг хэрэг	3,343,290.00	2,273,195.00
210402	Тээвэр, шатахуун	22,306,760.00	26,058,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,127,520.00	1,212,240
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,056,020.00	4,913,372.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>808,568,939.12</b>	<b>1,561,737,158.65</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	808,438,939.12	1,561,737,158.65
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	130,000.00	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,700,900.00</b>	<b>7,937,110.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	50,000.00
210604	Урсгал засвар	4,700,900.00	7,887,110.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,653,400.00</b>	<b>25,404,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	14,653,400.00	25,404,500.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>942,123,648.90</b>	<b>1,269,716,010.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	932,850,249.90	1,263,519,878.00
210803	Даатгалын үйлчилгээ	573,100.00	675,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	358,520.00	324,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	297,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,785,000.00	4,806,000.00
210807	Газрын төлбөр	259,779.00	82,412.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>298,078,184.06</b>	<b>273,287,542.64</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,372,475.53	5,040,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	7,560,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	253,705,708.53	260,687,542.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>117,774,545.28</b>	<b>243,281,889.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,124,900.00</b>	<b>25,238,033.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,705,900.00	21,798,033.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,419,000.00	3,440,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>92,649,645.28</b>	<b>218,043,856.17</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,649,645.28	218,043,856.17
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-223,535,436.21</b>	<b>-154,714,714.73</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-223,535,436.21</b>	<b>-154,714,714.73</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,740,552,709.90</b>	<b>2,642,163,070.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,833,450.00</b>	<b>27,914,350.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,833,450.00</b>	<b>27,914,350.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>10,833,450.00</b>	<b>27,914,350.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,833,450.00	27,914,350.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,729,719,259.90</b>	<b>2,614,248,720.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>925,871,600.00</b>	<b>1,184,410,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	925,871,600.00	1,184,410,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>803,847,659.90</b>	<b>1,429,837,820.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	403,510,499.90	371,703,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	400,337,160.00	1,058,134,220.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,716,852,709.90</b>	<b>2,625,293,170.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,716,852,709.90</b>	<b>2,625,293,170.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,599,078,164.62</b>	<b>2,382,011,280.83</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>440,157,409.17</b>	<b>731,404,118.18</b>
210101	Үндсэн цалин	350,052,576.03	543,246,594.50
210102	Нэмэгдэл	45,541,970.79	127,644,377.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,429,392.50	22,526,934.14
210104	Урамшуулал	22,133,469.85	37,986,212.05
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,748,214.33</b>	<b>97,922,798.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,400,347.76	65,717,475.62
210202	Тэтгэмжийн даатгал	4,517,687.96	7,392,589.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,018,438.07	10,307,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	801,067.65	1,318,666.73
210205	Эрүүл мэндийн даатгал	8,010,672.89	13,186,666.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,435,772.22</b>	<b>18,488,067.11</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,235,992.22	5,239,667.11
210302	Түлш, халаалт	13,199,780.00	13,248,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,674,670.00</b>	<b>36,518,400.00</b>
210401	Бичиг хэрэг	2,169,640.00	2,363,295.00
210402	Тээвэр, шатахуун	21,346,360.00	28,154,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,127,520.00	1,212,240.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,031,150.00	4,788,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>141,968,400.00</b>	<b>170,043,300.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	141,838,400.00	169,989,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	130,000.00	54,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,700,900.00</b>	<b>7,936,210.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	50,000.00
210604	Урсгал засвар	4,700,900.00	7,886,210.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,653,400.00</b>	<b>25,404,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	14,653,400.00	25,404,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>885,137,898.90</b>	<b>1,281,693,982.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	883,064,499.90	1,275,497,850.00
210803	Даатгалын үйлчилгээ	573,100.00	675,600.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	358,520.00	324,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	297,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	585,000.00	4,806,000.00
210807	Газрын төлбөр	259,779.00	82,412.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,601,500.00</b>	<b>12,600,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,601,500.00	5,040,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	7,560,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>117,774,545.28</b>	<b>243,281,889.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,124,900.00</b>	<b>25,238,033.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,705,900.00	21,798,033.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,419,000.00	3,440,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>92,649,645.28</b>	<b>218,043,856.17</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,649,645.28	218,043,856.17
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>23,700,000.00</b>	<b>16,869,900.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>23,700,000.00</b>	<b>16,869,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>23,700,000.00</b>	<b>16,869,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>23,700,000.00</b>	<b>16,869,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,700,000.00	16,869,900.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-23,700,000.00</b>	<b>-16,869,900.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	1,909,092,601.48	1,909,092,601.48
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	1,909,092,601.48	1,909,092,601.48
4	Өмчид гарсан өөрчлөлт	39,415,000.00	0	0	0
5	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
6	Тайлант үеийн үр дүн	0	0	-223,535,436.21	-223,535,436.21
7	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,415,000.00	0	1,685,557,165.27	1,724,972,165.27
8	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	39,415,000.00	0	1,685,557,165.27	1,724,972,165.27
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Өмчид гарсан өөрчлөлт				
12	Зарласан ногдол ашиг				
13	Тайлант үеийн үр дүн			-154,714,714.73	-154,714,714.73
14	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	39,415,000.00	0	1,530,842,450.54	1,570,257,450.54

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,194,410,900.00</b>	<b>1,212,325,250.00</b>	<b>-17,914,350.00</b>	<b>86.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,194,410,900.00</b>	<b>994,281,393.83</b>	<b>200,129,506.17</b>	<b>79.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,171,171,000.00</b>	<b>971,043,360.83</b>	<b>200,127,639.17</b>	<b>75.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>913,427,600.00</b>	<b>731,404,118.18</b>	<b>182,023,481.82</b>	<b>80.0</b>
210101	Үндсэн цалин	571,477,500.00	543,246,594.50	28,230,905.50	95.1
210102	Нэмэгдэл	246,739,600.00	127,644,377.49	119,095,222.51	52.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,671,000.00	22,526,934.14	11,144,065.86	66.9
210104	Урамшуулал	61,539,500.00	37,986,212.05	23,553,287.95	72.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>114,178,300.00</b>	<b>97,922,798.54</b>	<b>16,255,501.46</b>	<b>85.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	74,641,300.00	65,717,475.62	8,923,824.38	87.8
210202	Тэтгэмжийн даатгал	9,134,200.00	7,392,589.79	1,741,610.21	80.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,307,400.00	10,307,400.00		100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,826,800.00	1,318,666.73	508,133.27	72.1
210205	Эрүүл мэндийн даатгал	18,268,600.00	13,186,666.40	5,081,933.60	72.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,489,100.00</b>	<b>18,488,067.11</b>	<b>1,032.89</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,248,600.00	5,239,667.11	8,932.89	99.8
210302	Түлш, халаалт	13,240,500.00	13,248,400.00	-7,900.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,469,700.00</b>	<b>23,465,285.00</b>	<b>4,415.00</b>	<b>99.9</b>
210401	Бичиг хэрэг	2,363,400.00	2,363,295.00	105.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	13,587,200.00	13,584,150.00	3,050.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,213,200.00	1,212,240.00	960.00	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,305,900.00	6,305,600.00	300.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,428,300.00</b>	<b>8,428,300.00</b>		<b>100.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,374,200.00	8,374,200.00		100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	54,100.00	54,100.00		100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,474,300.00</b>	<b>15,466,100.00</b>	<b>8,190.00</b>	<b>99.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,587,600.00	7,579,900.00	7,700.00	99.9
210604	Урсгал засвар	7,886,700.00	7,886,210.00	490.00	99.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,990,100.00</b>	<b>5,988,500.00</b>	<b>1,600.00</b>	<b>99.9</b>
210702	Дотоод албан томилолт	5,990,100.00	5,988,500.00	1,600.00	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>71,118,400.00</b>	<b>69,300,182.00</b>	<b>1,818,218.00</b>	<b>96.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,701,700.00	63,081,050.00	1,620,650.00	96.9
210803	Даатгалын үйлчилгээ	680,300.00	675,600.00	4,700.00	99.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	331,400.00	324,120.00	7,280.00	97.8

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	311,100.00	308,000.00	3,100.00	99.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,004,700.00	4,829,000.00	175,700.00	96.5
210807	Газрын төлбөр	89,200.00	82,412.00	6,788.00	92.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>595,200.00</b>	<b>580,000.00</b>	<b>15,200.00</b>	<b>97.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,200.00	40,000.00	15,200.00	72.5
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	540,000.00	540,000.00		100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,239,900.00</b>	<b>23,238,033.00</b>	<b>1,867.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,239,900.00</b>	<b>23,238,033.00</b>	<b>1,867.00</b>	<b>100.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,798,200.00	21,798,033.00	167.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,441,700.00	1,440,000.00	1,700.00	99.9
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>218,043856.17</b>	<b>-218,043,856.17</b>	
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		218,043856.17	-218,043,856.17	
310001	Улсын төсвөөс санхүүжих	<b>1,194,410,900.00</b>	<b>994,281,393.83</b>	<b>200,129,506.17</b>	<b>79.0</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,184,410,900.00</b>	<b>966,367,43.83</b>	<b>218,043,856.17</b>	<b>78.5</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,184,410,900.00	966,367,43.83	218,043,856.17	78.5
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>10,000,000.00</b>	<b>27,914,350.00</b>	<b>-17,914,350.00</b>	<b>139.6</b>
610001	Төсвийн байгууллага	10,000,000.00	27,914,350.00	-17,914,350.00	139.6
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	<b>53</b>	<b>38</b>	<b>15.0</b>	<b>71.7</b>
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/  
 2017  
 2018  
 2019  
 2020  
 2021

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,429,837,820.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,429,837,820.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,427,837,820.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,570,020.00</b>
210402	Тээвэр, шатахуун	14,570,020.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>161,615,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,615,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>19,416,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	19,416,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,220,216,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,220,216,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,020,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,020,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,000,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,429,837,820.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,429,837,820.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	371,703,600.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газар /цаашид Мал эмнэлгийн газар гэх/ нь тайлант оныг “Хүн төвтэй хөгжлийн жил”, “Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил” болгон дэвшүүлсэн зорилтуудын хүрээнд доорх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах,
- Нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангах,
- Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх,
- Мал эмнэлгийн олон талт хамтын ажиллагааг сайжруулах,
- Нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангах,
- Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх ерөнхий болон тусгай арга хэмжээг зохион байгуулах,
- Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх ерөнхий болон тусгай арга хэмжээг зохион байгуулах,
- Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал, үүсэл, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, хяналт тавих, мал эмнэлгийн нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулах, сурталчлах, хяналт тавих,
- Мал эмнэлгийн салбарт хуулийн хэрэгжилтийг хангуулах,
- Төрийн захиргааны удирдлагын нэгдмэл байдлыг хангах,
- Санхүү, төсвийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх гэх мэт.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**


Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дугаар сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Мал эмнэлгийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ХХААХҮС-ын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/218 дугаар тушаалаар ХШҮДАГ-аас хяналт шалгалт хийгдэж, Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой 1 төлбөрийн акт,

бараа материал, үндсэн хөрөнгөтэй холбоотой 3 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/359 дүгээр тушаалаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсныг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,217.6 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.00	120,282.8	120,282.8
Бараа материал	207,063.8	178,649.2	(28,414.6)
Үндсэн хөрөнгө	1,567,694.1	1,391,608.3	(176,085.8)

<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,774,757.9</b>	<b>1,690,540.3</b>	<b>84,217.6</b>
Өр төлбөр	49,785.8	120,282.8	70,497.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,724,972.1	1,570,257.5	(154,714.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,774,757.9</b>	<b>1,690,540.3</b>	<b>84,217.6</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үүнд:

- Авлагын данс 120,282.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгогдох МЭУСАХЗ-ын олгогдоогүй санхүүжилтийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 176,085.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна,
- Өр төлбөрийн данс 120,282.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь тайлант оны эхэнд 49,629.6 мянган төгрөгийн мал эмнэлгийн 45 нэгжид өгөх төлбөрийг барагдуулсан, аймгийн ОНХС-аас санхүүжигдэх МЭУСАХЗ-ын цусны дээж авах үйлчилгээний хөлснийг дутуу олгосноос мал эмнэлгийн 47 нэгжид өгөх нийт 40,432.8 мянган төгрөгийн, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжигдэх эм эмнэлгийн хэрэгсэл, оношлуур нийлүүлэгч байгууллагад төлөх 79,850.0 мянган төгрөгийн өр төлбөр нэмж үүссэнээс тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.


#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Мал эмнэлгийн газрын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 889,520.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 37,240.3 мянган төгрөгөөр бууруулж, 852,280.4 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалингийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 91,507.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн,
- Байр ашиглалттай холбоотой зардлыг 30,453.4 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 29,288.8 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 6,791.7 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 26,465.7 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 15,103.9 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 9,701.8 мянган төгрөгөөр,
- Бараа, ажил үйлчилгээний бусад зардлыг 5,844.8 мянган төгрөгөөр,
- Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 5,098.1 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Тайлант оны эцэст МЭН-үүдийн тарилгын үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлээр тооцоноос батлагдсан төсвийг 342,130.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн зохицуулалт хийсэн байна.



### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,184,410.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 10,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 966,367.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 27,914.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 994,281.4 мянган төгрөг буюу 79.0 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 198,279.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Мал аж ахуйг хөгжүүлэх	589,277.0	521,578.6	67,698.4	87.5
2	Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого	581,894.0	449,464.8	132,429.2	77.2
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	23,239.9	23,238.0	1.9	100.0
	<b>Дүн</b>	<b>1,194,410.9</b>	<b>994,281.4</b>	<b>200,129.5</b>	<b>79.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130019405 тоот дансанд нийт 1,429,837.8 мянган төгрөгийн дараах орлогуудыг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- УМЭАЦТЛ-оос 4 төрлийн тандалт шинжилгээний зардалд 19,895.0 мянган төгрөг,
- МЭЕГ-аас 6 төрлийн өвчний тарилгын үйлчилгээний хөлс 1,038,239.2 мянган төгрөг,
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас МЭУСАХЗ-ын 355,683.6 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс “Хүнсний аюулгүй байдал-Мал эмнэлгийн оролцоо” сэдэвт зөвлөгөөн зохион байгуулахад 7,020.0 мянган төгрөг, байгууллагын шагнал урамшуулалд 2,000.0 мянган төгрөг, “БММӨУС дархлаажуулалтыг зохион байгуулахад 2,000.0 мянган төгрөг, “Мал эмнэлэг, үржлийн алба үүсэж, хөгжсөний 100 жилийн ой”-г тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд зориулан 5,000.0 мянган төгрөг зэрэг гэх мэт.

Нэмэлт төсвийн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,739,646.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **27,396.5** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор дараах зардлуудыг хэмнэж ажилласан байна. Үүнд:

- Ажилчдын цалин хөлс, нэмэгдэл, урамшлын зардлыг 182,023.5 мянган төгрөгөөр,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 16,255.5 мянган төгрөгөөр,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,818.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, татан төвлөрүүлсэн байна.



#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мал эмнэлгийн газар нь мэдээлбэл зохих 159 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,818.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэн, үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт


/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	2,818.9	3	2,818.9	100
Зөвлөмж	1	0.00	1	0.00	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>2,818.9</b>	<b>4</b>	<b>0.00</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр баригдаж буй Мал эмнэлгийн газрын барилгын лабораторийн барилга ашиглалтад ороогүй байхад түүнд ашиглагдах тоног төхөөрөмж, лабораторийн шинжилгээний эм урвалжийг “Медимпекс интернэшнл” ХХК 2021 онд нийлүүлж, нийт 94,544.6 мянган төгрөгийн урвалжийн хугацаа дуусаж, ашиглалтгүй болсон байна.

“Медимпекс интернэшнл” ХХК-ийн 2021 оны 02/294 дүгээр албан бичгээр хүргүүлсэн нийлүүлж буй барааны баталгаат хугацааны мэдэгдэлд *“Барилга ашиглалтад бүрэн орсны дараа тоног төхөөрөмжийг суурилуулснаас хойш баталгаат хугацааны 1 жилийг тооцно”* гэж заасны дагуу урьдчилан нийлүүлэгдсэн хугацаа дууссан эм урвалжийг тухайн компаниар шийдвэрлүүлсэн эсэх асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **9,330.0** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс **9,000.0** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **330.0** мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.



### 5.2 Албан шаардлага

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн батлагдсан төсвөөс нийт **9,000.0** мянган төгрөгийн багаж, техник хэрэгсэл худалдан авч, төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай бол төсөвт зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Бараа материалын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тээвэрлэсэн жолоочийн үнэмлэх, замын хуудас, ачааны фото зураг зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар Улаанбаатар, Дархан-Уул аймгаас ачаа тээвэрлэсний хөлсөнд нийт **330.0** мянган төгрөг олгож, бүртгэл тайланд тусгасан байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 13.7 дэх “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.





СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 39/А1820394  
СТА-2024/13-НА-СТА-ТШЗ

Сүхбаатар

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн батлагдсан төсвөөс нийт **9,000.0** мянган төгрөгийн багаж, техник хэрэгсэл худалдан авч төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*” журмын 4.2.1-д “*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*”, 4.2.1.11 “*Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн...*” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга С.Ариунтөгс, нягтлан бодогч С.Нороврэнцэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЦЭЦЭГ